



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 4/08

Мэргэн хошуу

Байгууллагын ёс зүйн хороог
шинэчилэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол мэдээллийг хүлээн авч түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах эрх бүхий ёс зүйн хороог 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Б.Аззаяа (Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн)
Гишүүд: С.Ууганбаяр (4 дүгээр багийн Засаг дарга)

П.Ганхэт (Санхүүгийн албаны дарга)

2.Төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, улс төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ханган ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг ёс зүйн хорооны дарга (Б.Аззаяа)-д даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/03 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ш. ОТГОНЖАРГАЛ

D:\bichig hereg\2025 он\ЗДТГ-ын тушаал.docx